



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

“Хас банк” ХХК-иас
гадаадын хөрөнгийн бирж дээр гаргах
үнэт цаасыг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 1.3, 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хас банк” ХХК-ийн гадаадын хөрөнгийн зах зээл дээр нийтэд санал болгон гаргаж буй 3 жилийн хугацаатай, 200,000,000 /хоёр зуун сая/ америк долларын үнийн дүн бүхий 1,000 ширхэг бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т үүрэг болгосугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 4.1-д заасны дагуу үнэт цаасны гадаадын хөрөнгийн зах зээл дээр байршуулсан тухай болон, арилжаалагдаж буй үйл явцын талаар хагас жил тутамд Хороонд ирүүлж, тайлагнаж байхыг “Хас банк” ХХК /Д.Бат-Очир/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН